ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ САНГИДОРЖИЙН БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх | | | | | | | |
| 1 | Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт | Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр | Тайлант хугацаанд буюу 2023.01.01-06.25-ны өдрийн байдлаар татварын орлогоор 2240.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2179.9 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлж 97.3 хувийн биелэлттэй байна. хураамжийн орлогоор 63,7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 70,3 тэрбум төвлөрүүлж төлөвлөгөөний гүйцэтгэл 110,3 хувийн биелэлттэй, | Эхний хагас жилд: Улсын төсөвт өссөн дүнгээр нийт 3297.3 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна.<br>- Татварын орлого 3226.2 тэрбум төгрөг,<br>- Хураамжийн орлого 63.7 тэрбум төгрөг,<br>- Өөрийн орлого 7.5 тэрбум төгрөг, | Гаалийн байгууллагын төсвийн нийт орлого 2024 онд 6727.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Эхний хагас жилд өссөн дүнгээр 3297.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2024.06.25-ны байдлаар 2988.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 90.6 хувийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн орлого 597.6 тэрбум төгрөгөөр илүү буюу 25.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Үүнээс: Татварын орлогоор 3226.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2912.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 90.3 хувийн биелэлттэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 579.0 тэрбум төгрөгөөр илүү буюу 34 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>-Хураамжийн орлогоор 2024 онд 130.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс эхний хагас жилд 63.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 70.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 110.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 18.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.<br>-Өөрийн орлого 2024 онд 15.0 тэрбум төгрөгийн төлөвлөгөөтэй, эхний хагас жилд | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - Өөрийн орлогоор тайлант хугацаанд 7,3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,6 тэрбум төгрөг төвлөрч биелэлт 77,3 хувьтай байна. | | 7.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2024.06.25-ны байдлаар 5.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 77.3 хувийн биелэлтэй байна. Өөрийн орлогын биелэлтэд БДШГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, тавигдсан төлбөрийн дүн төлөгдөхгүй шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн шатанд удаж байгаатай холбоотой байна.<br>6 дугаар сарын өдрийн дундаж орлого 27.6 тэрбум төгрөг байхаар тооцоход, хүлээгдэж буй гүйцэтгэл 3059.1 тэрбум буюу 93.0 хувийн биелэлттэй гарна.<br>Гаалийн байгууллагын төсвийн орлого 93.0 хувийн биелэлттэй буюу 238.2 тэрбум төгрөгөөр тасалдаж байна.<br>Гэвч улсын төсвийн гаалийн орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд УИХ, ЗГ-ын гаргасан шийдвэрүүд, ханшийн бууралт, тээвэр ложистикийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан, гаалийн болон онцгой албан татвар, тариф тэглэлт 4.1, татварын чөлөөлөлт 1.0, валютын ханшийн бууралтаас 129.25, татварын хойшлуулалт 30.0, тээвэр, ложистик хүндрэлээс 60.0, нийт 224.35 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлэх боломж алдагдсан байна.<br>Мөн импортын бараа эргэлтийн урсгалд Монгол Улс руу чиглэсэн чингэлэгийн тоог 40 орчим хувь болгож бууруулсан, Тяньжин боомтод чингэлэг ихээр бөөгнөрсөний улмаас 2024 оны эхний 4, 5, 6 дугаар сарын гаалийн орлого 308.4 тэрбум төгрөгөөр тасрахад нөлөөлөл үзүүлсэн байна. | | |
| 2 | Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлд зохион байгуулсан арга хэмжээ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 1. ГЕГ-ын даргын 2023-02-10-ны А/27 тоот “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь | Эхний хагас жилд:<br>- Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарийн тушаалыг | Нэг. Сангийн сайдын “Төсвийн хуваарь батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 281 дүгээр тушаалыг үндэслэн ГЕГ-ын даргын 2024-02-20-ны А/122 тоот /Хавсралт№3/ “Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай” | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлах тухай" тушаалыг батлуулан гаалийн газар хороодод хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. Үүнд:<br>- Хавсралт1. Харьяа гаалийн газар хороодын улсын төсвийн 2023 оны орлогын сар, улирлын хуваарь,<br>- Хавсралт2. Улсын төсвийн гаалийн орлогын сарын хуваарь,<br>- Хавсралт3. Улсын төсвийн бүрдүүлэлтийн хураамжийн орлогын сарын хуваарь,<br>- Хавсралт4. Улсын төсвийн өөрийн орлогын сарын хуваарь.<br>2. Гаалийн байгууллага нь дээрх тушаалын дагуу дараах ажлуудыг гүйцэтгэж ажиллалаа. Үүнд:<br>- Шуурхай хуралдаанд газар хороодод үүрэг даалгавар тухай | батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.<br>- Улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. | тушаалыг батлуулан гаалийн газар, хороодод хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Үүнд:<br>- Харьяа гаалийн газар, хороодын улсын төсвийн 2024 оны орлогын сар, улирлын хуваарь,<br>- Улсын төсвийн гаалийн орлогын сарын хуваарь,<br>- Улсын төсвийн хураамжийн орлогын сарын хуваарь,<br>- Улсын төсвийн өөрийн орлогын сарын хуваарь.<br>Хоёр. Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр 7 хоног тутмын шуурхай хуралдаанд ГЕГ-ын бүтцийн нэгжүүдийг болон газар, хороодын орлогын биелэлтийн явц, анхаарах асуудалд төвлөрч зохион байгуулах ажлын чиглэл, үүрэг даалгавар өгч, тодорхой ажлуудыг гүйцэтгэж ажилласан. Түүнчлэн харьяа гаалийн газар, хороодын сар бүрийн орлогын төлөвлөгөөний дүн шинжилгээг хүлээн авч, нэгтгэж удирдлагад танилцуулах ажлыг хэвшүүлсэн. ГЕГ-ын даргын тушаал "Бүтэц орон тоо батлах тухай" -аар 5 гаалийн газарт Татвар, бүрдүүлэлтийн албыг байгуулж, албаны дарга, ГУАБ, ГУБ нарын чиг үүргийг тодорхой болгосон.<br>ГГХ-ын удирдлагуудад улсын төсвийн орлогыг биелүүлэх чиглэлд онлайн хурлыг 2-3 удаа зохион байгуулж, энэхүү хурлаар ТОГ, ХБГ, БАУХ, СДШХ, БЦТ-ийн дарга нарыг оролцуулан чиг үүргийн дагуу мэдээллийг өгч, харилцан мэдээлэл солилцож, шийдвэрлэвэл зохих асуудалд анхаарал хандуулж, дэмжлэг туслалцааг үзүүлж ажилласан.<br>Гурав. ГЕГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 16-ний өдрийн Орлогын төлөвлөгөө биелүүлэх тухай албан бичиг, хавсралтын хамт харьяа гаалийн газар, хороодод хүргүүлэн ажилласан. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүр өгч, тодорхой ажлуудыг гүйцэтгэж ажилласан.<br>- Түүнчлэн харьяа гаалийн газар, хороодын сар бүрийн орлогын төлөвлөгөөний дүн шинжилгээг хүлээн авч нэгтгэж удирдлагад танилцуулсан.<br>- СЯ-ны шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар харьяа гаалийн газар хороодоос нэгтгэн, дүн шинжилгээ танилцуулга бэлтгэн тухай бүр хүргүүлэн ажиллалаа.<br>- ГЕГ-ын 2023-02-09-ний 01/507 албан тоотоор Улсын төсвийн орлого төлөвлөгөө биелүүлэх үүрэг даалгавар зарим гаалийн газар хороодод хүргүүлэн ажилласан. | | Дөрөв. Тээвэр ложистикийн асуудлаар УБТЗ ХНН-ийн холбогдох асуудал хариуцсан орлогч дарга, газар, хэлтсийн дарга, мэдээлэл технологийн албаны дарга, инженерүүдтэй 2 удаагийн уулзалт хурлыг хийж, гаалийн байгууллагын төлөөлөлд дэд дарга, ХБГ, ТОГ, БЦТ, МТГ, УБГГ-ын дарга, ГУАБ нарыг оролцуулж, протокол байгуулж, хамтран ажиллах, цахимаар харилцан мэдээлэл солилцох чиглэлд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.<br>Мөн төмөр замын болон чингэлэг тээвэрлэлт, өртөө дээр ирэхээс өмнөх мэдээллийг урьдчилан авах, гаалийн хяналт бүрдүүлэлтийг цаг алдалгүй, хурдан шуурхай бүрдүүлэлтийг хийх ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Тав. Дэд дарга "2024 оны улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр авчч хэрэгжүүлэх шуурхай ажлын төлөвлөгөө" баталсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Улсын төсвийн гаалийн орлогын төсвийн төслийг хүргүүлэх, мэдээ, тайлан дүн шинжилгээг сар бүр гаргаж, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон удирдлагад хүргүүлж мэдээллээр хангасан байдал | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар | 1. УИХ-ын Тамгын газар, Сангийн яамны орлогын хэлтэст Улсын төсвийн орлогын дүн шинжилгээ бүхий статистик мэдээг сар бүр хүргүүлэн ажиллалаа. Үүнд:<br> Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээ 2022 он /29 хуудас/,<br> 2023 оны 1 сар- 22 хуудас,<br> 2023 оны 2 сар – 25 хуудас,<br> 2023 оны 3 сар – 27 хуудас,<br> 2023 оны 4 сар - 30 хуудас,<br> 2023 оны 5 сар – 30 хуудас.<br>2. СЯ-ны шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг харьяа гаалийн газар, хороодоос авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, | Эхний хагас жилд: Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээг 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1, 2, 3, 4, 5 дугаар саруудын мэдээг сар бүрийн эхний 7 хоногт багтаан гаргаж, төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн танилцуулга, экспортын эрдэс бүтээгдэхүүний мэдээ, эрдэс бүтээгдэхүүн экспортлогч ААН-ийн импортын татварын мэдээг нэгтгэж, УИХ-ын Тамгын газар болон Сангийн яам, удирдлагуудад хүргүүлсэн байна. | 1. УИХ-ын Тамгын газар, Сангийн яамны орлогын хэлтэст Улсын төсвийн орлогын дүн шинжилгээ бүхий статистик мэдээг сар бүр хүргүүлэн ажиллалаа. Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээ 2023 он, 2024 оны эхний 1, 2, 3, 4, 5 дугаар сард боловсруулж хүргүүлсэн. Ингэхдээ төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулга, хавсралт статистик мэдээллүүдийг багтаадаг болно.<br>УИХ-ын Тамгын газар, Сангийн яамны Орлогын хэлтэст Улсын төсвийн орлогын дүн шинжилгээ бүхий статистик мэдээг сар бүр хүргүүлэн ажиллалаа. Үүнд:<br> Улсын төсвийн гаалийн орлогын статистик мэдээ 2023 он /30 хуудас/,<br> 2024 оны 1 сар- 24 хуудас,<br> 2024оны 2 сар – 25 хуудас,<br> 2024 оны 3 сар – 27 хуудас,<br> 2024 оны 4 сар - 30 хуудас,<br> 2024 оны 5 сар – 30 хуудас.<br><br>2. Үндэсний аудитын газраас 2023 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийгдэж буйтай холбогдуулан Гаалийн байгууллагын 2023 оны төсвийн орлогын гүйцэтгэл, бусад холбогдох мэдээллийг хүргүүлэн ажилласан.<br><br>3. Сангийн сайдын баталсан "Гаалийн ерөнхий газар болон гаалийн газар, хороодын үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж"-ийн дагуу Гаалийн байгууллагын 2022, 2023 онуудын санхүү, төсвийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд хийгдсэн шалгалтын бүрэлдэхүүнд холбогдох төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг хүргүүлэн ажилласан. | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | танилцуулга бэлтгэн тухай бүр хүргүүлэн ажиллалаа. | | | | |
| 4 | Улсын төсвийн гаалийн орлогын хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэх, хүргүүлэх, хугацаа хэтэрсэн татварын өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, суутган тооцолт, татварын баталгаа гаргах, түр горимын дансны үлдэгдлийн хяналт зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавих | Хэрэгжилт, гүйцэтгэлээр Гаалийн хяналт, бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа, хувиар, Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар | 1. Сангийн яамны Төрийн сангийн газарт Гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор буюу хугацаанд нь 5 удаа гаргаж, цахимаар болон тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулсан. | Эхний хагас жилд:<br>- Гаалийн байгууллагын татварын орлогын 2023 оны жилийн эцсийн тайланг газар, хороодоос хүлээн авч, нэгтгэж нэгтгэсэн тайланг Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.<br>- Сангийн яамны Төрийн сангийн газарт гаалийн байгууллагын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор буюу хугацаанд нь 5 удаа гаргаж, цахимаар болон тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулсан байна.<br>- Хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах, буцаан олголт, хойшлуулалт, | - Сангийн яамны Төрийн сангийн газарт Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 8-ны дотор буюу хугацаанд нь 5 удаа гаргаж, цахимаар болон тайлангаар хүргүүлж, тооцоо нийлэн баталгаажуулан ажилласан.<br>- Улсын төсөвт төвлөрүүлэх гаалийн орлогын 2023 оны жилийн эцсийн орлогын гүйцэтгэлийг харьяа газар, хороодтой тооцоо нийлж тулган баталгаажуулсан тайланг гаалийн газар, хороодоос хүлээн авч татвар, хураамж, өөрийн орлого, түр горимын нэгтгэл тайланг гаргаж, баталгаажуулан СЯ-ны Төрийн сангийн газрын санхүүжилт, бүртгэлийн газарт хуулийн хугацаанд нь буюу 2024-03-07 ны өдрийн 01/899 тоот албан албан бичгийн хавсралтаар хүргүүлэн нэгтгүүлсэн.<br>- Төсөвт төвлөрүүлсэн орлогыг төрөл тус бүрээр гаалийн газар, хороодтой сар бүр тооцоо нийлж баталгаажуулан татвар, хураамж, өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн мэдээг газар, хороодоор гаргаж гаалийн байгууллагын “Захиргааны статистик мэдээлэл”-д оруулахаар СДШХ-т 5 удаа файлаар хүргүүлэн ажилласан.<br>- Газар, хороодоос түр горим, хойшлуулалт, өр авлагын барагдуулалттай холбоотой мэдээ, тайланг сар бүр хүлээн авч нэгтгэн буцаан олголт, суутган тооцолт, татварын баталгаа, түр горимын дансны үлдэгдэлд хяналт тавин ажилласан бөгөөд татварын хойшлуулалттай холбоотой өр, авлага нэмж үүсгээгүй, татварын буцаан олголттой холбоотой ямар нэгэн гомдол | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | суутган тооцолт, татварын баталгаа, түр горимын дансны үлдэгдэлд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлт хяналт тавьж ажилласан байна. | гараагүй, барьцаа татвартай холбоотой ямар нэгэн өргөдөл, гомдол ирээгүй байна.<br>-Сангийн яам, Гаалийн ерөнхий газар болон арилжааны банкуудтай 2021 оны 12 дугээр сарын 27-ний өдөр байгуулсан Тэг үлдэгдэлтэй дансны 2023 оны хэрэгжилтийг гэрээний заалт тус бүрээр дүгнэж Төрийн сангийн газарт хүргүүлсэн.<br>-Шилэн дансны мэдээллийг https://info.shilendans.gov.mn хуудсанд 5 удаа оруулсан.<br>-"ТОСК" ХК-ийн хугацаа хэтэрсэн өр болох 3.3 тэрбум төгрөгөөс 1.6 тэрбум төгрөгийг төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн. Ингэснээр хугацаа хэтэрсэн нийт өр авлагыг 5-аас дээш хувиар бууруулж, тайлант хугацаанд нэмж өр авлага үүсгээгүй байна.<br>-“Монцемент билдинг материалс” ХХК-ийн холбогдох төлөөлөлтэй 2024 оны 3, 4 дүгээр сарууддад ГЕГ дээр хоёр удаа уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар үлдэгдэл өр төлбөрийг яаралтай барагдуул гэсэн шаардлагыг тавьсан бөгөөд тус компанийн зүгээс ТЕГ дээр НӨАТ-ын суутган тооцолтыг тооцуулж, үлдэгдэл татварын өрийг төлж барагдуулах санал гаргасаны дагуу НӨАТ-ын системд холбогдох өөрчлөлтийг хийж байна. | | |
| 5 | Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, Туршилт хийсэн болон шалгаруулсан аж ахуйн нэгжийн тоогоор | 2023 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02-4/17 тоот албан бичгээр тухайн онд хэрэгжүүлэх татварын чөлөөлөлтийн хууль тогтоомжийн чиглэлийг гаалийн газар хороодод хүргүүлсэн.<br>Гаалийн тариф, | Эхний хагас жилд:<br>- Гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөн бүрмөсөн болон түр хугацаагаар орох гаалийн бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж, зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна. | Тайлант хугацаанд татварын чөлөөлөлттэй холбоотойгоор батлагдсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх чиглэлийг тухай бүрт албан тоотоор газар, хороодод хүргүүлж, хуулийн хэрэгжилтэд хяналтыг ханган ажиллаж байна.<br>Тайлант онд хэрэгжүүлэх татварын чөлөөлөлтийн хууль тогтоомжийн чиглэлийг гаалийн газар, хороодод 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 02-2/04 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Газар, хороодод 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн "Гаалийн албан татвараас | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | татварын хуулийн 38 дугаар зүйл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйл болон бие даасан 6 хууль, Засгийн газрын 11 тогтоолын дагуу татварын чөлөөлөлтийг хэрэгжүүлэн ажиллаж 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 416 аж ахуйн нэгж, 41 иргэний 245.4 сая ам.долларын бараанд ногдох гаалийн татвар 30,3 тэрбум, НӨАТ 78,5 тэрбум, онцгой албан татвар 141,4 сая, нийт 109,0 тэрбум төгрөгийн татварыг чөлөөлсөн байна.-Засгийн газрын зээл, тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх тухай албан хүсэлт тус газарт нийт 353 бүртгэлийн | | чөлөөлөх тухай хууль", Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтыг үндэслэн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаанбуудайн гурилыг гаалийн албан татвараас чөлөөлөх чиглэлийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 02-2/1720 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Холбогдох хууль, тогтоомжийн дагуу эхний хагас жилд нийт 279.07 сая ам.долларын бараанд ногдох 42.15 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 227.3 сая төгрөгийн онцгой албан татвар, 139.11 тэрбум төгрөгийн НӨАТ ыг чөлөөлсөн байна.<br>Үүнд: -Гаалийн болон бусад татвараас чөлөөлөх хүсэлтийг edoc.ecustoms.mn цахим хуудсаар ирүүлсэн бичиг 229, хүсэлтийг шийдвэрлэж Гаалийн газар, хороод руу явуулсан 108 албан бичиг.<br>-Засгийн газрын зээл, тусламжийн хүрээнд татвараас чөлөөлүүлэх тухай албан хүсэлт нийт 601 бүртгэлийн хуудсаар https://odamis.mof.gov.mn цахим хуудсаар хүлээн авч баталгаажуулан 87.07 сая USD бараанд 14,498.6 сая төгрөгийн гаалийн татвар, 227.6 төгрөгийн онцгой албан татвар, 30,970.7 сая төгрөгийн НӨАТ-ийн татварыг чөлөөлсөн байна. Татвараас чөлөөлөгдөж бүрдүүлэлт хийгдсэн барааны даатгалын зардлыг 7 мэдүүлэг тус бүрт хувааж хийлгээгүй, илүү дүнгээр татварын чөлөөлөлт эдлүүлсэн мэт алдааг залруулж засварлуулсан. Сангийн яамнаас ирүүлсэн 2024 оны 01 дүгээр сарын 29-ний 01/519 тоот албан бичгийн дагуу “10 аймгийн төвийн дулааны станц барих” төслийн гүйцэтгэгч Бюксан инженеринг төлөөний газрын 2023 онд импортолсон техникийн шаардлага хангахгүй шугам хоолойн татвараас чөлөөлөгдсөн гаалийн мэдүүлгийг хүчингүй болгож, гаалийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хуудсыг https://odamis.mof.gov.mn цахим хуудсаар хүлээн авч баталгаажуулан газар хороодод цахимаар хүргүүлсэн байна. Бусад татварын чөлөөлөлтийн 247 албан тоотыг http://edoc.ecustoms.mn/ цахим хуудсаар дамжуулан хүлээн авч 151 албан бичгийг эрх бүхий албан тушаалтнуудаар хянан, баталгаажуулж газар, хороодод цахимаар илгээж ажилласан. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн нутаг дэвсгэрт татвараас чөлөөлж, түр хугацаагаар оруулах горимоор 6 албан тоотыг газар хороодод хүргүүлж ажилласан байна. | | болон нэмэгдсэн өртгийн албан татварыг төлүүлэх арга хэмжээг авч ажилллаж байна. Энэ хүрээнд тус компанид 2 удаа албан тоотыг хүргүүлж, 5 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.Эхний хагас жилд 1.1 сая ам.долларын бараанд 601.0 сая төгрөгийн татварыг төлүүлсэн. 2024-04-09-ны өдрийн 02-2/1343 тоот албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>1. Гаалийн газар, хороодод шинээр батлагдсан болон одоо мөрдөгдөж буй татварын чөлөөлөлттэй холбоотой хууль тогтоомжийн талаар хоёр удаа чиглэл хүргүүлсэн.<br>2. Татвараас чөлөөлөгдөж бүрдүүлэлт хийгдсэн 7 мэдүүлэгт даатгалын зардлыг мэдүүлэг тус бүрт хуваан хийлгүй бүх зардлыг мэдүүлэг тус бүрт оруулж, илүү дүнгээр татварын чөлөөлөлт эдлүүлсэн мэт алдааг залруулж засварлуулсан.<br>3. 2024 оны 01 дүгээр сарын 01- ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 25 -ний өдрийг хүртлэх хугацааны татварын чөлөөлөлтийн мэдээнд дүн шинжлгээ хийж, Татвараас чөлөөлөгдөж бүрдүүлэлт хийгдсэн 4 гаалийн мэдүүлэгт чөлөөлөлтийн код буруу оруулсан алдааг засварлуулж, зөв болгосоны дүнд 11,023,714.71 төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн байна. | | |
| 6 | Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилт | Цахим хуудсаар лавлах | 1. ЭЗТХ-ийн дагуу 990 барааны гаалийн тарифын | Эхний хагас жилд: | 1. Засгийн газрын 2024 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20% байснийг 2024 | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэгээр түгээсэн мэдээллийн тоо, Цахим хуудасны хандалтын тоо, Лавлах цэгээр үйлчлүүлсэн хэрэглэгчийн тоо, хувиар, Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | хөнгөлөлтийг тарифын санд шинэчлэн оруулсан. ЗГ-ын тогтоолоор Дизель түлшний ОАТ, АИ-92 автобензиний гаалийн албан татварыг “0” хувь хэмжээгээр тогтоосон хувь хэмжээг тарифын санд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.<br>2. Чөлөөт худаладааны хэлэлцээрийн талаар 3 удаа чиглэл хүргүүлж, хөнгөлөлттэй тарифт хамрагдсан 300 гаалийн мэдүүлэгт хяналт тавьж, газар хороодод 3 албан бичиг хүргүүлж Гачуурт ХХК-иар 1.3 сая төгрөгийн гаалийн татварыг нөхөн төлүүлсэн.<br>3. Дэлхийн Худалдааны Байгууллагын нэгдсэн цахим санд оруулах Монгол Улсын 2023 оны тарифын | - Гаалийн тариф, гарал үүсэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, харьяа гаалийн газар, хороодыг зөвлөмж чиглэлээр хангаж ажилласан байна. | оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5% болгон бууруулсаныг тарифын санд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Нийт 4.1 сая ам.долларын дүн бүхий 64 тонн, 4.1 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.<br>2. Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны мэдээллийн нэгдсэн цахим санд оруулах Монгол Улсын 2024 онд мөрдөх импортын барааны гаалийн нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф, импортын статистик мэдээллийг ДГБ-аас ирүүлсэн загварын дагуу гарган хүргүүлсэн.<br>3. Монгол- Японы ЭЗТХ-ээр 2024 оны эхний хагас жилд 117.2 сая ам.долларын бараанд 20.2 тэрбум төгрөгийн, АНДХХ-ийн хүрээнд 7.4 сая ам.долларын бараанд 154 сая төгрөгийн гаалийн татварын хөнгөлөлт үзүүлсэн байна. Эхний хагас жилийн байдлаар хөнгөлөлттэй тарифт хамрагдсан 42 ААН-ийн 2005 гаалийн мэдүүлгийг нягтлан шалгаж 2 мэдүүлгийг засварлуулахаар БЦТ-д 2024/80 дотоод зурвас хүргүүлсэн.<br>4. ДГБ-аас Дэлхийн Худалдааны Байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр, Гарал үүслийн Хэлэлцээр, тэдгээрийг хэрэгжүүлэх Дэлхийн Гаалийн байгууллагын Гарал үүслийн дүрмийн Компендиум, Гарал үүслийг урьдчилан тодорхойлох болон бусад гарал үүслийн дүрэмтэй холбоотой сертификаттай сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан. Уг сургалтад ГЕГ-ийн бүтэцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар хороодоос нийт 30 албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.<br>5. Монгол улс БНСУ-тай байгуулах ЭЗТХ-ийн Хоёр дахь шатны хэлэлцээ Улаанбаатар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдэгдлийг 02-2/1330 албан бичгээр болон цахимаар нийт 1075 хуудас материал боловсруулан ГХЯ-нд хүргүүлсэн.<br>4. Ерөнхий Сайд 2023 оны Дугаар 55 захирамжаар Монгол улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын Эдийн засгийн хэлэлцээр байгуулах ажлын хэсгийн Дэд ажлын хэсэгт Гарал үүсэл хариуцан ажилласан. БНСУ-тай хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын 2017-2022 оны гаалийн тариф, татварын судалгааг гаргаж, ГХЯ-аар дамжуулан хүргүүлсэн. | | хотноо 2024 оны 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Хэлэлцээрийн төсөлд санал өгч, APTA, MFN хамаарах 6359 барааны тарифын жагсаалт болон холбогдох мэдээллийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>6. МХАҮТ-аас зохион байгуулсан Европын холбооны "Монгол Улсад Гадаад Худалдааг Хөгжүүлэх" (ITDM) төслийн сургалтуудад хамрагдсан.<br>7. Дэлхийн гаалийн байгууллагаас анх удаа Монголын гаалийн байгууллагад Дэлхийн Худалдааны Байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр, Гарал үүслийн Хэлэлцээр, тэдгээрийг хэрэгжүүлэх Дэлхийн Гаалийн байгууллагын Гарал үүслийн дүрмийн Компендиум, Гарал үүслийг урьдчилан тодорхойлох болон бусад гарал үүслийн дүрэмтэй холбоотой сургалтыг Гаалийн ерөнхий газарт 2024 оны 03 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уг сургалтад ГЕГ-ийн бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодоос нийт 30 албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлж, сертификат гардуулсан. Сургалтын нээлтэд ГЕГ-ын дэд дарга Г.Энхтайван, Mr. Demba Seck, /Technical Officer, Tariff and Trade Affairs Directorate/, Mr. Masaya /DEGUCHI, WCO Accredited Expert, Japan Customs/, Mr. Keisuke /ARAKI, Senior Inspector, Moji Customs, Japan Customs/ нар оролцсон. | | |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ТОГ нь 2023 оны эхний хагас жилд гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний | Эхний хагас жилд:<br>- Гаалийн байгууллагын бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг | “Алсын хараа-2050"-д тусгагдсны дагуу УИХ-ын 2022 оны "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах, Улсын их хурлын 2023 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Гаалийн албан татварыг хөнгөлөх | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | хангаж ажилласан байна. | тухай хууль, Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 107 дугаар тогтоолоор батлагдсан гаалийн албан татвараас хөнгөлөх хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийн жагсаалтад хамаарагдах барааг импортолсон 59 аж ахуйн нэгжийн 2023 онд ногдуулсан гаалийн албан татвар болох 2.1 тэрбум төгрөгийн гаалийн албан татварыг буцаан олгох хүсэлтийг хүлээн авч, нягтлан шалгаж Сангийн Яамны төрийн сангийн газарт 3 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан. | | |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэл ээр | ТОГ нь 2023 оны эхний хагас жилд хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. | Эхний хагас жилд:<br>-Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хханган ажиллаж, тухай бүр холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргэсэн байна. | Доорх мэдээ тайланг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүнд:<br>- Сангийн яаманд 2024 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 02-2/276 тоот албан бичгээр 2023 оны төсвийн зарлагын мэдээг хүргүүлсэн.<br>- Гаалийн болон бусад татварын чөлөөлөлттэй холбоотой хуулийн хэрэгжилтийн биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн Хуулийн хэлтэст хүргүүлсэн.<br>- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн 01/1724 тоот албан бичгийн хүрээнд Засгийн газрын 107 дугаар тогтоолын биелэлтийг сүүлийн 2 жилийн байдлаар гаргаж хүргүүлсэн.<br>-УИХ-аас 2024 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулсан "Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцлийг хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол"-д холбогдох эрх зүйн баримт, мэдээлэл бэлтгэн оролцсон. Татварын чөлөөлөлтөөр импортлогдсон сүүлийн 5 жилийн эмийн мэдээг гаргаж оролцсон.<br>- УИХ-ын Түр хорооноос зохион байгуулсан "Ногоон автобусны" нээлттэй сонсголд оролцсон удирдлагуудад татвараас | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чөлөөлөгдөж орж ирсэн автобусны 2 жилийн мэдээг гаргаж өгсөн.<br>- Архидан согтууруулахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих санд хөрөнгө төвлөрүүлэх журмын 1.2, 2.2 зүйл заалтын дагуу хэрэгжилтийн тайланг ГЕГ-ийн 2023-05-08-ний 02/1704 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлсэн. - 2015 оны 190-р тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, "Монголын алт" ХХК, "Эрдэнэс цагаан суврага" ХХК-ны хооронд 2023 оны 05 сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээний дагуу Эрдэнэс цагаан суврага ХХК нь гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд ногдуулсан 22.8 тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Говь-Алтай аймгийн Тайшир суманд байрлах “Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад зориулан импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, "Цэнгазар" ХХК-ийн хооронд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 2024/73/47 гэрээний гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл Ховд аймгийн Булган дахь гаалийн газарт хүргүүлж 2024 оны 3 дугаар сарын 31-нээс эхлэн 3.6 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.<br>- Сангийн яам, Гаалийн ерөнхий газар болон арилжааны банкуудтай 2021 оны 12 дугээр сарын 27-ний өдөр байгуулсан Тэг үлдэгдэлтэй дансны 2023 оны хэрэгжилтийг гэрээний заалт тус бүрээр дүгнэж Төрийн сангийн газарт хүргүүлсэн.<br>- Шилэн дансны мэдээллийг https: //info.shilendans.gov.mn хуудсанд 05 удаа хугацаандаа “Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт”-ийн талаар мэдээллэж ажилласан. | | |
| 9 | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Татвар, орлогын газар нь 2023 оны эхний хагас жилд ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж ажилласан. | Эхний хагас жилд: ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Мэргэжлийн зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж ажилласан байна. | 1.Тайлант хугацаанд Удирдлагын шуурхай хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Захиргааны зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас ТОГ-т өгсөн нийт 6 үүрэг даалгавар, 2 зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.<br>2. Сангийн яамны АУДИТ-д татварын чөлөөлөлтийн мэдээг сүүлийн 2 жилээр гаргаж танилцуулсан.<br>3. СЯ-ны шуурхай хуралдаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт хүлээгдэж буй гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар харьяа гаалийн газар, хороодоос нэгтгэн, дүн шинжилгээ танилцуулга бэлтгэн тухай бүр хүргүүлэн ажиллалаа.<br>4. Гаалийн ерөнхий газрын дэд даргын баталсан “Гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавих, гарал үүслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний хүрээнд газар, хороодод хөнгөлөлттэй гарал үүслийн гэрчилгээтэй бараанд хяналт тавьж ажилласан. | 2024.01.01 - 2024.06.30 | |
| Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Төсвийн орлогын төлөвлөг өөний биелэлт төгрөгөөр , хувиар | | Эхний хагас жилд: Нэгжийн эрсдэлийг таньж тогтоон ангилсан байна. | 1. Улсын төсвийн орлого бүрдүүлэх, статистик мэдээ боловсруулах, дүн шинжилгээ хийх чиглэлд эрсдэл тооцон ажилласан. Энэ чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.<br>-БНХАУ-ын Тьянжин боомт дахь ачаа, чингэлэг төвлөрч, бөөгнөрөл үүссэн, хэрхэн Монгол улс руу татан авах талын мэдээллийг УБТЗ ХНН-ээс урьдчилан авах ажлыг зохион байгуулж, тухай бүр Сангийн яаманд хүргүүлэн холбогдох мэдээллээр ханган ажилласан.<br>- Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр ажлын хэсэгт орж ажиллаж байна.<br>- МУИС Гаалийн байгууллагын хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд Улсын төсвийн орлогыг таамаглах төсөл хийх чиглэлээр Бизнесийн дээд сургуулийн захиралтай ТОГ, СДШХ-ийн дарга, ГУАБ, ГУБ нар уулзалт хийж, санал солилцож, хамтран ажиллаж байна.<br>2. Бүрдүүлэлтийн цахим төвд Засгийн газрын 107 дугаар тогтоолд хамаарахгүй барааг оруулсан эсэхийг нягтлан шалгаж, алдааг засварлуулахаар 2024/12 дугаартай дотоод зурвасыг хүргүүлж ажилласан.<br>3. Татварын чөлөөлөлтөөр хийгдсэн бүрдүүлэлтийн хамгийн их алдаа гардаг эрсдэл өндөртэй горимын код, хэлцлийн код, чөлөөлөлтийн кодыг 401, 402, 403 горимтой уялдуулан, нягтлан шалгаж 25 алдааг илрүүлж, мэдүүлгийг засварлуулж ажилласан.<br>4. Гарал үүслийн чиглэлээр эрсдэл тооцож, эхний хагас жилийн байдлаар хөнгөлөлттэй тарифт хамрагдсан 42 ААН-ийн 2005 гаалийн мэдүүлгийг нягтлан шалгаж 2 мэдүүлгийг засварлуулахаар БЦТ-д 2024/80 дотоод зурвас хүргүүлсэн. Үүний дагуу БЦТ-өөс 2024.06.26-ны өдрийн 92 дугаар дотоод зурвасаар дээрх хоёр мэдүүлгийг засварлаж, | 2024.01.01 - 2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэг мэдүүлгийн хөнгөлттэй тарифыг ердийн тарифаар тооцож, дутуу төлсөн татварыг нөхөн төлүүлж шийдвэрлэсэн байна.<br>5. Засгийн газрын шийдвэрээр гурвалсан гэрээ байгуулан 2 жилийн хугацаагаар хойшлуулсан татварын эргэн төлөлт Сангийн яамтай шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа гэсэн шалтгаанаар хугацаандаа төлөгдөхгүй болох эрсдэл үүсч болзошгүй байгааг олж тогтоож, гурвалсан гэрээнд эргэн төлөлтийг тодорхой график гарган гэрээний хугацааны эцэст буюу 2 жилийн хугацаанд тэнцүү хуваан төлж дуусгахаар заасан заалт оруулах саналыг Сангийн яаманд хүргүүлсэний дараа гэрээнд холбогдох заалтыг тусгуулсан. Үүний дагуу одоо хэрэгжиж байгаа татварын хойшлуулалтад 2 жилд багтаан график гарган хуваан төлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. | | |
| 2 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Татвар, орлогын газрын албан хаагчдын 2023 оны эхний хагас жилийн цаг ашиглалт 99.7% -тай байна. | Эхний хагас жилд: Ажлын цагийн хоцролт, тасалдалгүй ажилласан байна. | ГЕГ-ын даргын 2022.10.24 А/226-р тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 9 дүгээр зүйл “Ажил, амралтын цаг”-д заасаны дагуу албан хаагчийн ажилд ирсэн, явсан цагийг нүүр таних системд буюу цаг бүртгэлийн төхөөрөмжид бүртгүүлж ажлын цагийг баталгаажуулж хэвшсэн.<br>2024.01.01-2024.01.15 хүртэл хугацаанд бүтэн ажилласан. 2024 оны ээлжийн амралтыг 2024.01.15-2024.02.13 хүртэл хугацаанд биеэр эдэлсэн. | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | |
| 3 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, хувиар | | Эхний хагас жилд:<br>1. Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br>2. Гаалийн байгууллагын 2024 | 1. ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн А/339 тоот тушаалаар "Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, зохион байгуулах, зөвлөмж чиглэлээр хангах, дүн шинжилгээнд суурилсан шийдвэр гаргах үүрэг бүхий ажлын хэсэг, статистик мэдээлэлд суурилсан дүн шинжилгээ хийх, үр дүнг | 2024.01.01<br>-<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлтсийн чиг үүрэгт хамааралтай арга хэмжээний биелэлтийг хангаж ажилласан байна.<br>3. Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний газрын чиг үүрэгт хамааралтай арга хэмжээний биелэлтийг хангаж ажилласан байна. | тооцон, тайлагнах баг"ийг байгуулсан. Ажлын хэсэгт ТОГ-ын дарга С.Баярмаа, нарийн бичгийн даргаар ГУАБ Б.Эрдэнэбат, дүн шижилгээний багийн гишүүнээр ГУБ Д.Ганцэцэг нар орж ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулсан бөгөөд дүн шинжилгээний үндсэн дээр хийж хэрэгжүүлэх ажлын чиглэлийг гарган холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажиллаж байна.<br>2. МХАҮТ-ын даргын 2024 оны 3 дугаар сарын 31-ний А/31 тоот ТОП-100 аж ахуйн нэгж эрэмбэлэх ажлын хэсэгт ГУБ Д.Ганцэцэг орж ажилласан бөгөөд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>- МҮХАҮТ-д 2023 оны байдлаар Улсын төсөвт төвлөрүүлсэн гаалийн албан татвар, импортын НӨАТ, АБДТАТ, онцгой албан татваруудын орлогыг ААНБ-уудаар эрэмбэлж эхний 500 ААНБ-ын мэдээллийг /policy@mongolchamber.mn/ цахим хаягаар хүргүүлсэн.<br>- МҮХАҮТ-д 2024.05.15-нд болсон МУ-ын ТОП-100 ААНБ эрэмблэх ажлын хэсгийн эхний шатны эрэмбэлэх ажлын уулзалтанд оролцсон.<br>3. Гаалийн харилцаанд оролцогч иргэн Б.Бат-Энх нь БНСУ-аас KIA Morning загварын тээврийн хэрэгсэлийг 2023.12.04-ны өдөр улсын хилээр импортлосон бөгөөд гаалийн байгууллагад 2023.12.20-ны өдөр 02-2151010-23-I34926 дугаартай гаалийн мэдүүлгээр мэдүүлсэн. Уг тээврийн хэрэгслийн техникийн паспортод үйлдвэрлэсэн он 2013.12.19 өдөр буюу 10 жил 1 өдөр болсонтой холбогдуулан мэдүүлэгч тээврийн хэрэгслийн үйлдвэрлэсэн оноос хойшхи хугацааг 7-9 жил гэж үзэж онцгой албан татварын ногдуулалттай холбоотой гомдлыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан. Анхан шат болон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | давж заалдах шатны шүүх хуралуудад ТОГ-ын гаалийн тариф, татвар, гарал үүслийн дүрэм, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хариуцсан ГУБ оролцсон.<br>4.ДГБ-аас Дэлхийн Худалдааны Байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр, Гарал үүслийн Хэлэлцээр, тэдгээрийг хэрэгжүүлэх Дэлхийн Гаалийн байгууллагын Гарал үүслийн дүрмийн Компендиум, Гарал үүслийг урьдчилан тодорхойлох болон бусад гарал үүслийн дүрэмтэй холбоотой сертификаттай сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулсан. Уг сургалтад ГЕГ-ийн бүтэцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар хороодоос нийт 30 албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.<br>5. Монгол улс БНСУ-тай байгуулах ЭЗТХ-ийн Хоёр дахь шатны хэлэлцээ Улаанбаатар хотноо 2024 оны 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Хэлэлцээрийн төсөлд санал өгч, APTA, MFN тарифын жагсаалт болон холбогдох мэдээллийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн.<br>6. МХАҮТ-аас зохион байгуулсан Европын холбооны "Монгол Улсад Гадаад Худалдааг Хөгжүүлэх" (ITDM) төслийн сургалтуудад хамрагдсан.<br>7. Үндэсний аудитын газраас Сангийн яаманд хийгдсэн шалгалтын баг, Сангийн яамны Аудитын газраас ГЕГ-т хийгдсэн шалгалтын багуудад ТОГ-ын чиг үүрэгт хамаарах ажлын мэдээ, мэдээлэл, дүн шинжилгээ, тайланг тухай бүр гарган өгч ажилласан бөгөөд аудитын шалгалтын тайланд зөрчил дурдагдаагүй болно.<br>8. “Монголын гааль” цахим хуудсанд Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаалийн татвар, тариф, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаархи мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж ажиллаж байна.<br>9. Татвар орлогын газрын нийт албан хаагчид 7 хоног бүрийн "Мэдээллийн цаг"-т бүрэн хамрагдаж идэвхтэй оролцож байна. Мөн тус газраас 2024 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Иргэдийн хэрэглээний боловсролын төвийн шим тэжээл судлаач, Био анагаахын ШУ магистр, сансар марс төсөлийн хоол зүйч Э. Нэмүүзол “Эрүүл зөв хоололт, амьдралын зөв дадал, зуршил, хамт олны дотоод уур амьсгал” сэдвээр Мэдээллийн цаг зохион байгуулж, ГЕГ-ын албан хаагчид идэвхитэй оролцлоо.<br>10. Мод тарих хөдөлгөөнд оролцож, Хөшигтийн хөндийд очиж мод тарьсан.<br>11. Гаалийн цом-2024 тэмцээний хөтөлбөрийн дагуу гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулах ажлыг хариуцсан. | | |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр, сургалтын тоогоор | - | Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байна. | 2024 оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалт буюу ЗГХЭГ-ын харьяа Төрийн удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн зохион байгуулсан Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан.<br>Удирдлагын академийн захирлын 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн А/119 тоот тушаалаар № А4582 тоот сертификат олгосон.<br>Голч дүн 3.36 | 2024.01.01 - 2024.06.30 | 100 |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлэ эр, | - | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна. | Япон Улсын Сангийн яамнаас санаачлан Монгол-Японы гаалийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээрийн хүрээнд Япон улсын Токио хотноо 2024 оны 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Бүрдүүлэлтийн дараах шалгалт болон барааны ангилал, үнэлгээ"-ний чиглэлийн сургалтад ГЕГ-ын БАУХ, БДШГ, БЦТ-ийн ГУАБ, ГУБ нарын хамт оролцож, гаалийн хэргийн болон хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлсэн.<br>Сургалтаар олж авсан Барааны ангилал, үнэлгээ, бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлийн мэдээлэл, цаашид ажилдаа туршлага болгох, хэрэгжүүлэх саналын талаар газар, хэлтэс, төвийн хамт олонд танилцуулахын зэрэгцээ гаальчдад нээлттэй мэдээлэл болгон серп гадаад сургалт хэсэгт танилцуулга, тайланг байршуулсан. | 2024.01.01 - 2024.06.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТАТВАР ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................ /С.БАЯРМАА / 2024.06.30

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

ТАТВАР, ОРЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ САНГИДОРЖИЙН БАЯРМААГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Татвар орлогын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 60.0 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | | 14 |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 14 |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 14 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1 | Хандлага, ёс зүй | 14 |
| 2 | Удирдан зохион байгуулах | 14 |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4 | Манлайлах | 13 |
| 5 | Багаар ажиллах | 12 |
| 6 | Харилцаа | 14 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар | 13 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 60.0 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 87 |

| | |
|---|---|
| **Үнэлгээ өгсөн:** | **Төсвийн шууд захирагч** |
| Гаалийн ерөнхий газрын дарга | ............................ (Р.Отгонжаргал) |
| | 2024.06.19 ............................ (огноо) |
| **Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:** | **Нэгжийн дарга:** |
| Татвар, орлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | С.Баярмаа ............................ (С.Баярмаа) |
| | 2024.06.21 ............................ (огноо) |